



ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.03.15 № 03/360

танай _____-ны № _____-т

Хүсэлт гаргах тухай

Тус газарт Нийслэлийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/133 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 10 дахь заалтаар эрх шилжин ирсэн Ахмад настан, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах “Сонгинохайрхан” төслийн тоног төхөөрөмж (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг) /ЭМЯ/20240102040/ төсөл, арга хэмжээ Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/237 дугаар захирамжаар худалдан авах ажиллагааны эрх нь Сонгинохайрхан дүүргийн Засаг даргад шилжиж буй тул Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-нд хүчингүй болгож өгнө үү.

Хавсралт 3 хуудастай.



Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар
Удирдлага
Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Даваадорж Батцэцэг
2024.03.15 14:01



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/237

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталж, 1 дэх заалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Сүхбаатар дүүргийн Засаг дарга (Х.Болормаа)-д, 2 дахь заалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Баянгол дүүргийн Засаг дарга (Ө.Сумъяабаатар)-д, 3 дахь заалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Багануур дүүргийн Засаг дарга (С.Даваасүрэн)-д, 4 дэх заалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга (Н.Алтаншагай)-д тус тус шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг үүрэг болгосугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалтын тасаг (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Энхжин)-т, 1 дэх заалтын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Нийтийн тээврийн газар" (Д.Отгонжаргал)-т, 2, 3 дахь заалтын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ (С.Цэдэнсодном)-т, 4 дэх заалтын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга (Н.Алтаншагай)-д, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/42 дугаар захирамжийн 4 дүгээр хавсралт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/112 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар баталсан жагсаалтын 2 дахь заалт,

1110201203

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/133 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар баталсан жагсаалтын 3, 10 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
...03... дугаар... сарын 05... өдрийн
...А/237... дугаар... захирамжийн
хавсралт



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төг)

Д/д	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах		
1	XV.3.2.1	Нийтийн тээврийн автобусны буудлын тохижилт, шинэчлэл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2024	2024	1,000.0	1,000.0
2	XII.1.90	Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2024	2026	12,570.0	3,570.0
3	XVI.3.39	Хүлэмжийн аж ахуй /Улаанбаатар, Налайх, Багануур дүүрэг/	2024	2024	500.0	500.0
4	XVIII.3.3	Ахмад настан, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах "Сонгинохайрхан" төслийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2024	2024	100.0	100.0
Дүн					14,170.0	5,170.0